

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА



### МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ЭРГЭЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН ҮҮСГЭХ /ГААЛЬ, ХИЛИЙН БООМТЫН МЭДЭЭЛЛИЙГ НЭГТГЭХ/ АЖЛЫН ДААЛГАВАР

2024оны ... дугаар сарын ... өдөр  
хот

Дугаар.....

Улаанбаатар

1	Үйлчилгээний нэр	Монгол Улсын гадаад худалдааны эргэлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх /гааль, хилийн боомтын мэдээллийг нэгтгэх/ судалгаа
2	Захиалагч	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо
3	Үйлчилгээ гүйцэтгэх хугацаа	Нийт хугацаа: 30 хоног Эхлэх: 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр Дуусгах: 2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр
4	Зөвлөх үйлчилгээний төсөв	50,000,000
5	Үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 21.4 Олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграци болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 4.2 Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно. Үүний дотор Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлсэн байна, 4.4, Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө, 8.1, Өрнө-Дорнын бүсийн орнуудыг холбох дэд бүтцийн хөндлөн гол тэнхлэгийн авто зам болон хойд, урд хөршийг холбох зарим бүсийн босоо тэнхлэгийн авто замыг барьж худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна, Шинэ сэргэлтийн бодлогын Боомтын сэргэлтийн хүрээнд 1.1.Боомтуудын хатуу, зөвлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ, 1.2 Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилгтай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг

		сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ, 1.3.1 Агаарын замын байнгын ажиллагаатай олон улсын боомтын тоог нэмэгдүүлж, карго тээвэр, аялал жуулчлалыг хөгжүүлэх”, “Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, б нисэх буудлыг зорчигч, ачаа тээврийн харилцааны хилийн олон улсын боомт болгосон байна. Иймд, дээрх бодлогын зорилго, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үүднээс Монгол улсын гадаад худалдаа, хилийн боомттой холбоотой мэдээллийн нэгдсэн сан үүсгэх хэрэгцээ, шаардлага байна.
6	<b>Судалгааны зорилго</b>	Монгол Улсын урт, дунд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан хилийн боомтын сэргэлттэй холбоотойгоор хилийн боомтуудаар гадаад худалдаа, экспорт, импортын мэдээллийн нэгтгэх сан үүсгэх
7	<b>Үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил</b>	<p>Монгол улсын гадаад худалдааны эргэлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх /гааль, хилийн боомтын мэдээллийг нэгтгэх/ судалгааны хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хилийн боомтуудаар экспорт, импортын мэдээлэл, барааны ангилал төрлөөр, хэмжээ, мөнгөн дүнгээр <ul style="list-style-type: none"> <li>○ Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн</li> <li>○ Ургамлын гаралтай бүтээгдэхүүн</li> <li>○ Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх</li> <li>○ Хүнсний бэлэн бүтээгдэхүүн</li> <li>○ Эрдэс бүтээгдэхүүн</li> <li>○ Химиин болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн</li> <li>○ Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс</li> <li>○ Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл</li> <li>○ Мод, модон эдлэл</li> <li>○ Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс</li> <li>○ Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл</li> <li>○ Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл</li> <li>○ Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн</li> <li>○ Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос</li> <li>○ Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн</li> </ul> </li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>○ Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг</li> <li>○ Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги</li> <li>○ Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги</li> <li>○ Зэвсэг, галт хэрэгсэл; тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл</li> <li>○ Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа</li> <li>○ Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс</li> <li>● Хилийн боомт бүрээр гадаад худалдаа хийсэн улсын тоо, чиглэл</li> <li>● Хилийн боомтуудын зорчигч, нэвтэрсэн тээврийн хэрэгсэлийн мэдээллийн сан бүрдүүлэх.           <ul style="list-style-type: none"> <li>○ Хилийн боомтоор нэвтэрсэн зорчигчдын тоо</li> <li>○ Хилийн боомтоор нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо</li> </ul> </li> <li>● Хилийн боомтуудын хорио цээргэй бараа бүтээгдэхүүн нэвтрүүлэх эрхийн мэдээлэл</li> <li>● Гаалийн салбар лабораторийн байршил, шинжилгээний төрлийн мэдээлэл</li> <li>● Хилийн боомтуудын суурь дэд бүтцийн мэдээлэл           <ul style="list-style-type: none"> <li>○ Хилийн боомтой холбогдох авто замын зэрэглэлийн мэдээлэл</li> <li>○ Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлын мэдээлэл, хүн, ачаа, тээврийн хэрэгсэлээр</li> <li>○ Хилийн боомтуудын эрчим хүчний сүлжээнд холбогдсон байдал</li> </ul> </li> </ul> <p>Зөвлөх үйлчилгээний хүрээнд дээрх мэдээллийн сангцахим хэлбэрээр, мэдээллийн сангийн агуулгыг бүхий тайланг цаасан хэлбэрээр боловсруулж өгнө.</p>
8	<b>Үйлчилгээний ажлын хүрэх үр дүн болон хэрхэн ашиглах талаар төсөөлөл</b>	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг, төсөл арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэхэд шаардлагатай Монгол улсын гадаад худалдааны эргэлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх /гааль, хилийн боомтын мэдээллийг нэгтгэх/ судалгааг хийж гүйцэтгэнээр цаашид төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглана.
9	<b>Судалгааны тайлангийн үе шат</b>	<p><u>Эхлэлийн тайлан:</u>            Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор буюу 20...оны ...-р сарын....-ны өдөр дараах ажлыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.</p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Уг тайланд ажлын даалгавар, гэрээний зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хуваарь багтана.</li> </ul> <p><u>Эцсийн тайлан:</u></p> <p>Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор буюу 20...оны ... дугаар сарын ...-ны өдөр дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө.</p> <ul style="list-style-type: none"> <li>a) Ажлын даалгаварт заасан дата, мэдээллийг цахим хэлбэрээр өгнө, /*.excel, ShP.file өргөтгөлтэй/;</li> <li>b) Мэдээллийн сангийн товьёо, агуулгыг бүхий тайланг цаасан хэлбэрээр захиалагчид өгнө /*.doc өргөтгөлтэй/;</li> </ul>
--	--